



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/654

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 134 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 134 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 30 нэр төрлийн нийт 21,746,160.00 (хорин нэгэн сая долоон зуун дөчин зургаан мянга нэг зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 134 дүгээр сургууль (Б.Хашхүү)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 11 нэр төрлийн 4,000,900.00 (дөрвөн сая есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 19 нэр төрлийн 17,745,260.00 (арван долоон сая долоон зуун дөчин таван мянга хоёр зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 134 дүгээр сургууль (Б.Хашхүү)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЮУМАА

11505010/2

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 463 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын 134 дугаар сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	ҮХХХК-ын шийдвэр
1.Тоног төхөөрөмж													
1	Компьютер иж бүрэн	4	ш	1	996,600.00	996,600.00	996,600.00	-	эвдэрсэн	актлах	20,000	татах	татах
2	Хувилагч /hegox/	5	ш	1	2,600,000.00	2,600,000.00	2,600,000.00	-	эвдэрсэн	актлах	20,000	татах	татах
3	Принтер /hegox/	5	ш	1	138,000.00	138,000.00	138,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
4	Компьютер /иж/	4	ш	1	950,000.00	950,000.00	950,000.00	-	эвдэрсэн	актлах	15,000	татах	татах
5	Компьютер /иж/	4	ш	2	1,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
6	Компьютер /иж/	5	ш	2	1,230,000.00	2,460,000.00	2,460,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
7	Компьютер-1	5	ш	2	585,000.00	1,170,000.00	1,170,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
8	Принтер /3 үйлдэлт/	5	ш	2	369,900.00	739,800.00	739,800.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
9	Принтер өнгөт	5	ш	1	399,900.00	399,900.00	399,900.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
10	Проктер	5	ш	2	750,000.00	1,500,000.00	1,500,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
11	Өсгөгч	5	ш	1	890,000.00	890,000.00	890,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
12	Дефузер	5	ш	2	490,000.00	980,000.00	980,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
13	Ус буцалгагч /том/	5	ш	1	280,000.00	280,000.00	280,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
14	Ус буцалгагч /жижиг/	5	ш	3	95,000.00	285,000.00	285,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
15	Ус буцалгагч /жижиг/	5	ш	1	201,000.00	201,000.00	201,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
16	Принтер АРМFР-M125A	5	ш	1	369,900.00	369,900.00	369,900.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
17	Хард	5	ш	1	271,160.00	271,160.00	271,160.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
18	Цаг бүртгэлийн төхөөрөмж	5	ш	1	400,000.00	400,000.00	400,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	татах	татах
19	Ус буцалгагч /анги /	5	ш	1	95,000.00	95,000.00	95,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
20	Ус буцалгагч /анги /	5	ш	3	100,000.00	300,000.00	300,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
21	Ус буцалгагч /анги /	5	ш	3	100,000.00	300,000.00	300,000.00	-	эвдэрсэн	актлах	10,000	усгах	усгах
22	Ламинаторын машин	5	ш	1	90,000.00	90,000.00	90,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	усгах	усгах

